



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3 нэрийн, 89,900,000.00 (наян есөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000130

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оны 02 дугаар сарын 20-ны/ний өдрийн  
02 дугаар тогтоолын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР  
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр, төрөл, арал, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Хуандэй старекс, тусгай зориулалтын, КМJWA37RAAU193452 арлын, 6803УНБ улсын дугаартай	2009	37,950,000.00	5,000,000.00
2	Хуандэй старекс, тусгай зориулалтын, КМJWA37RAAU193434 арлын, 6801УНБ улсын дугаартай	2009	37,950,000.00	5,000,000.00
3	Ниссан экс-трэйл суудлын автомашин, JN1TBNT30Z0111649 арлын, 1903 УБЦ улсын дугаартай	2006	5,000,000.00	4,000,000.00
НИЙТ ДҮН			80,900,000.00 (наян сая есөн зуун мянга)	14,000,000.00 (арван дөрвөн сая)